

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Завхан-АЗЗА” ТӨХК-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/03/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn Аудитын менежер: Х.Болдбаатар Утас: 99105506 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Жалбаа Утас: 89330330 Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улаанбаатар, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

"ЗАВХАН-АЗЗА" ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.БАТТУЛГА-Д

2024.05.11 № 221
талай _____ ны № _____ -Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Завхан-АЗЗА" ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшний гүйцэтгэлд аудит хийлээ.

"Завхан-АЗЗА" ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Богино хугацаатай өр төлбөр өмнөх оноос 205.1 сая төгрөгөөр өссөн хэдий ч байгууллагын үйл ажиллагааны алдагдал өмнөх оноос 156.4 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитын гол асуудал

"Завхан-АЗЗА" ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшний гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар хуримтлагдсан ашгийг зөрүүтэй илэрхийлсэн зөрчил байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 572.97 км улсын чанартай авто замын урсгал засвар, арчлалтыг хариуцан гүйцэтгүүлэх 634.8 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшний гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

0100000005

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Үзүүлэлтийн нэр	Үлдэгдэл	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	813,355.38	190,480,020.50
1.1.2. Дансны авлага	206,348,696.01	0.01
1.1.11. Эргэлтийн хөрөнгийн дүн	537,943,808.50	551,112,691.43
1.1.3. Татвар НДШ-ийн авлага	2,280,426.79	1,260,847.61
1.1.4. Бусад авлага	120,175,961.08	119,020,113.18
1.1.6.Бара материал	182,289,369.23	214,315,710.13
1.1.7. Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	26,036,000.00	26,036,000.00
1.2.1 Үндсэн хөрөнгө	948,738,006.13	922,366,161.16
1.2.2 Биет бус хөрөнгө	95,696,000.00	95,696,000.00
1.2.12 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,044,434,006.13	1,018,062,161.16
1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,582,377,814.63	1,569,174,852.59
2.1.1.1 Дансны өглөг	187,955,336.07	244,632,633.33
2.1.1.2 Цалингийн өглөг	5,843,029.50	28,785,137.26
2.1.1.3 Татварын өр	61,540,322.45	187,027,509.98
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	255,338,688.03	460,445,280.57
2.1.2.2 Нөөц өр төлбөр	277,652.70	0.00
2.1.2.5 Зээл	291,360,199.00	291,360,199.00
2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн	291,637,851.70	291,360,199.00
2.2 Өр төлбөрийн нийт дүн	546,976,539.73	751,805,479.57
2.3 Эздийн өмч	431,714,192.00	431,714,192.00
2.3.1 Төрийн	431,714,192.00	431,714,192.00
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	73,020,780.11	73,020,780.11
2.3.8 Эздийн өмчийн бусад хэсэг	622,638,311.76	647,638,311.76
2.3.9 Хуримтлагдсан ашиг	-91,972,008.97	-335,003,910.85
2.3.11 Эздийн өмчийн дүн	1,035,401,274.90	817,369,373.02
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,582,377,814.63	1,569,174,852.59

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Үзүүлэлтийн нэр	төгрөгөөр	
	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Борлуулалтын орлого(Цэвэр орлого)	1,430,392,476.36	2,274,507,523.64
2.Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,356,876,615.64	1,933,442,281.59
3. Нийт ашиг (алдагдал)	73,515,860.72	341,065,242.05
5. Хүүний орлого	0.00	24,424.01
8. Бусад орлого	2,930,438.40	0.00
9. Борлуулалт, маркетингийн зардал	0.00	167,000.00
10. Ерөнхий ба удирдлагын зардал	240,047,659.08	330,975,450.25
12. Бусад зардал	106,069.51	16,264,880.69
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(163,707,429.47)	(6,317,664.88)
19. Орлогын татварын зардал	0.00	992,279.18
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(163,707,429.47)	(7,309,944.06)
22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(163,707,429.47)	(7,309,944.06)
23. Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	25,000,000.00
Бусад олз (гарз)	0.00	25,000,000.00
24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	(163,707,429.47)	17,690,055.94

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	431,714,192.00	73,020,780.11	622,638,311.76	-91,972,008.97	1,035,401,274.90
3	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-7,309,944.06	-7,309,944.06
9	2024 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	431,714,192.00	73,020,780.11	647,638,311.76	-335,003,910.85	817,369,373.02

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	1,404,370,222.41	2,618,377,190.01
1.1 Мөнгөн орлогын дүн	1,404,370,222.41	2,618,377,190.01
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,364,125,450.00	1,853,259,433.36
Бусад мөнгөн орлого	40,244,772.41	765,117,756.65
1.2 Мөнгөн зарлагын дүн	1,448,603,706.98	2,407,677,124.89
Ажиллагчдад төлсөн	353,083,173.17	471,667,359.87
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	93,305,764.80	60,367,546.03
Бараа материал худалдан авахад төлсөн	486,801,714.04	414,437,851.66
Ашиглалтын зардал төлсөн	18,987,331.98	229,350,536.28
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	207,993,821.50	545,380,493.43
Татварын байгууллагад төлсөн	120,120,307.98	93,060,457.10
Даатгалын төлбөрт төлсөн	0.00	53,320,110.14
Бусад мөнгөн зарлага	168,311,593.51	540,092,770.38
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(44,233,484.57)	210,700,065.12
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
Мөнгөн зарлагын дүн	0.00	15,000,000.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	15,000,000.00
2.20 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	0.00	(15,000,000.00)
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(27,319.00)	(6,033,400.00)
Мөнгөн зарлагын дүн	27,319.00	6,033,400.00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	27,319.00	6,033,400.00
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	27,319.00	6,033,400.00
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(44,260,803.57)	189,666,665.12
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	45,074,158.95	813,355.38
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	813,355.38	190,480,020.50

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 он		2023 он	
			Төлөвлөгөө	ХБГ	Төлөвлөгөө	ХБГ
1	Нийт орлого	мян.төг	1,094,292.0	1,353,111.8	1,227,262.9	2,274,531.9
	Үүнээс: Улсын чанартай 33А	мян.төг	939,757.8	1,353,111.8	1,177,262.9	1,947,879.6
	Бусад	мян.төг	154,534.2	-	50,000.0	326,652.3
2	Нийт зардал	мян.төг	1,092,791.6	1,521,657.9	1,221,126.6	2,280,849.6
3	Удирдлагын зардалд	мян.төг	201,485.2	3,667.0	253,972.4	330,975.4
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	1,500.4	(167,946.1)	6,136.3	(6,317.6)
5	Цэвэр ашиг /алдагдал	мян.төг	1,350.4	(151,151.5)	5,522.7	(7,309.9)
6	Төсвийн төлбөрт	мян.төг	156,468.0	179,500.0	193,264.5	277,385.2
7	Төрийн өмчийн ноогдол ашиг	мян.төг	202.5	-	2,761.3	-
8	Нийт авлага	мян.төг	106,432.5	362,748.8	112,748.8	120,280.9
9	Нийт өглөг	мян.төг	328,514.3	333,725.6	316,514.4	751,805.4
	Үүнээс: Урт хугацаат/Кувейтийн сан/	мян.төг	291,360.1	291,360.1	291,360.1	291,360.1
	Богино хугацаат	мян.төг	37,154.2	42,365.5	25,154.3	460,445.2
10	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян.төг	0.999	0.980	0.995	1.020
11	Хөрөнгө оруулалт	мян.төг	89,000.0	50,500.0	25,000.0	73,800.0
12	Ажиллагсдын тоо	хүн	38.0	38.0	38.0	44.0
13	Цалингийн сан	мян.төг	295,274.0	399,344.3	415,365.3	498,570.3
14	Нэг ажилтаны дундаж цалин	мян.төг	778.80	875.76	910.89	944.20

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа

“Завхан-А33А” ТӨХК нь төрийн захиргааны төв байгууллагаас баталгаажуулсан улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтыг төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэж, түүгээр өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг жилийн туршид саадгүй байлгах үүргийг бүрэн хангаж, ашгийн төлөө ажилладаг ТӨБЗГ-ын харьяа байгууллага юм.

2023 онд улсын болон орон нутгийн чанартай зам засварын хүрээнд 1,227.3 сая төгрөгийн ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн байна.

3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

“Завхан-А33А” ТӨХК нь үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Авто замын тухай хууль, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Завхан-АЗЗА” ТӨХК-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Завхан-АЗЗА” ТӨХК-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13.2 сая төгрөгөөр буюу 0.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	813.4	190,480.0	189,666.6
Авлага	328,777.7	120,281.0	-208,496.7
Урьдчилж төлсөн зардал	26,036.0	26,036.0	0
Бараа материал	182,316.7	214,315.7	31,999.0
Үндсэн хөрөнгө	1,044,434.0	1,018,062.2	-26,371.8
Нийт хөрөнгө	1,582,377.8	1,569,174.9	-13,202.9
Өр төлбөр	546,976.5	751,805.5	204,829.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,035,401.3	817,369.4	-215,031.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,582,377.8	1,569,174.9	-13,202.9

Дээрх хүснэгтээс харахад данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

- Авлага өмнөх оноос 208.5 сая төгрөгөөр буурсан нь зам арчлалтын санхүүжилтийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.
- Урьдчилж төлсөн зардал өөрчлөгдөөгүй нь 2022 онд Агуйтын хөтлийн шуурхайн хэсэгт 26.0 сая төгрөгөөр байр барих ажил хийгдсэн хэдий ч газрын гэрчилгээтэй холбоотой маргаан үүссэний улмаас хүлээн авч, данс бүртгэлд тусгаагүй байна.
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл буурсан нь тайлант онд 25.0 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй нийлүүлэгдсэн, 47.0 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, хөрөнгийн элэгдлийн зардал 98.4 сая төгрөгөөр тооцсон зэрэгтэй холбоотой байна.

- Өр төлбөр өмнө оноос 204.8 сая төгрөгөөр өссөн нь зам арчлалтын санхүүжилт оройтож орж ирсэнтэй холбоотой байна гэж үзлээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2022 оны 588 дугаар тогтоолоор 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,227.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,221.1 сая төгрөгөөр, 5.5 сая төгрөгийн ашигтай ажиллагаагаар баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 25.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 2,274.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,280.8 сая төгрөгийн зардал гарган, 6.3 сая төгрөгийн татвар төлөхийн өмнөх алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 2,274.5 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,047.2 сая төгрөг буюу 85.3 хувиар, нийт зардлын гүйцэтгэл 2,280.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,059.7 сая төгрөг буюу 86.8 хувиар өссөн нь орон нутгийн зам, гүүрийн засварын ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажилласан, шинээр улсын чанартай авто зам нэмэгдсэн, хувь хүн, хуулийн этгээдээс зээл авсан зэрэгтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын арга хэмжээний хүрээнд 73.8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна. Үүний 25.0 сая төгрөг нь балансаас шилжин ирсэн хөрөнгө байна.

Тайлант онд цэвэр алдагдал 7.3 төгрөг болж өмнөх оноос 95.5 хувиар буурсан байна.

ТӨБЗГ-т тайлант онд ногдол ашгийн болон түрээсийн орлогоор хөрөнгө төвлөрүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу "Завхан-АЗЗА" ТӨХК-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх ТӨХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн ТӨХК-ын үйл ажиллагааг сайжруулах нягтлан бодох бүртгэл, төсвийн зарцуулалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Жалбаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Завхан-АЗЗА ТӨХК-ын 2023 оны санхүүгийн тайланг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 1,356.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 20.4 сая төгрөгөөр тогтоосон байна.

Материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,340.8 сая төгрөгийн 1.5 хувь буюу 35.1 сая төгрөгөөр дахин тооцооллоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Завхан-АЗЗА ТӨХК нь албан томилолт, бичиг хэргийн зардлыг хэмнэх, удирдлагын харилцаа холбооны зардлыг байгууллагаас төлөхийг зогсоох, үндсэн үйл ажиллагаанд шаардагдах бараа материал, сэлбэг хэрэгслээс бусад худалдан авалт хийхгүй, дотоод нөөцөөр хангах, шатахууны үргүй зардал гаргахгүй байх, үйлдвэрлэлийн ажлыг нягтруулж, сул зогсолтыг багасгах, орон тоо нэмэгдүүлэхгүй байх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өмнөх аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханга ажиллах зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Завхан-АЗЗА” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар худалдан авсан 6.3 сая төгрөгийн материалыг шууд зардлаар тайлагнасан, алба хаагчдад хууль журамд тусгагдаагүй 1.1 сая төгрөгийн нэмэгдэл олгосон, биеийн тамирын хослол 1.9 сая төгрөгөөр худалдан авсан, Шилэн дансны цахим мэдээлэлд орлого, зардлын 287.8 сая төгрөгийг мэдээлээгүй зэрэг 297.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	3	9,351.1	3	9,351.1	100
Нийт дүн					100

Өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг санхүүгийн аудитын Фас системд бүртгэсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үзэх эрсдэлтэй асуудал байхгүй байна гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 235.7 сая төгрөгийн алдаа¹ илэрсэнд залруулах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Үүнд: Хуримтлагдсан ашиг дансны үлдэгдлийг 235.7 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн алдаа илэрсэн байна. Санхүүгийн тайланг холбогдох хуулийн хугацаанд Сангийн яамны Э-тайланд шивж нэгтгүүлсэн тул засвар хийх боломжгүй гэсэн тайлбар ирүүлсэн тул 2024 оны эхний хагас жилийн тайланд залруулга хийх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Аудитаар зөрчил² илрээгүй байна.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөх зөрчил илрээгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. НББ тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хуримтлагдсан ашиг дансны үлдэгдлийг 235.7 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", гэсэн заалт, аудитын тохиолдсон байх, толилуулга гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуримтлагдсан ашиг дансны үлдэгдлийг зөрүүтэй илэрхийлсэн алдааг 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэхүү зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 08 дугаар сарын 01-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хуримтлагдсан ашиг дансны үлдэгдлийг зөрүүтэй илэрхийлсэн	1	235,721.9			1	235,721.9			1	235,721.9	1	235,721.9
Дүн	1	235,721.9			1	235,721.9			1	235,721.9	1	235,721.9

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

[illegible]

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/												
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Үүнээс							
					Төлбөрийн акт		Албан шаардлага				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Дүн												
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Дүн												
Нийт дүн												

БОЛОВСРУУЛСАН : АХЛАХ АУДИТОР

Б.ЖАЛБАА

2024.03.11

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

2024.03.11

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР

2024.03.11

